



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

183 /183/

2021.11.18

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ЭДИЙН ЗАСАГ, ХУДАЛДААНЫ ХАМТАРСАН ХОРООНЫ ХУРАЛДААН АМЖИЛТТАЙ БОЛЛО



Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын Эдийн засаг, худалдааны хамтарсан хорооны IX хуралдаан Бүгд Найрамдах Турк Улсын нийслэл Анкара хотноо амжилттай зохион байгуулагдлаа. Тус хуралдаанаар хоёр орны худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, бизнесийн хамтын ажиллагаа болон хөдөө аж ахуй, аялал жуулчлал, чөлөөт бүс, зам тээвэр зэрэг салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, харилцан тохиролцоонд хүрлээ. Хоёр талын хамтарсан хорооны дарга, Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Бүгд Найрамдах Турк Улсын Дотоод хэргийн сайд С.Сойлу нар ажлын протоколд гарын үсэг зурж баталгаажуулав.

Түүхэнд энэ өдөр

1970 он.

БХЯ-ны сайдын тушаалаар Барилгын цэргийн зам барилгын 58 дугаар тусгай батальоныг байгуулжээ.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-2	-10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
36	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.0	2,854.0
EUR	3,275.0	3,285.0
CNY	445.80	449.80
RUB	38.50	40.00
JPY	24.65	25.23
KRW	2.38	2.46

ЗУРХАЙ

2021.11.18 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 14/

ӨВЛИЙН ТЭРГҮҮН ШАРАГЧИН ГАХАЙ САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН МОРЬ ӨДӨР

Үс засуулбал: Эд мал арвидна.

НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 08.03-17.12

Барилдлага: Хүчин төгсөх Шүтэн барилдлага: Хуран үйлдэхүй

Суудал: Төмөр

Энэ өдөр бар жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, угаал үйлдэх, тангараг тавих, гэр бүрэхэд сайн. Хэрүүл тэмцэл хийх, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одоосод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.

“ЭНХИЙГ САХИУЛАХ АЖИЛЛАГААНД МОНГОЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Монгол цэрэг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцсоны 20 жилийн ойг угтан зохион байгуулагдах олон улсын хурлын арга хэмжээний бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлэх, энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн эмэгтэйчүүдийн туршлага, сургамжийг үнэлж дүгнэх, цаашдын оролцооны бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох, үндэсний болон салбарын удирдлагын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн өнөөдөр “Энхийг сахиулах ажиллагаанд Монгол эмэгтэйчүүдийн оролцоо” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний бага хуралд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Ц.Тогоо, Батлан хамгаалахын

дэд сайд Б.Баярмагнай, ҮБХИС-ийн захирал, бригадын генерал, дэд профессор П.Жаргалан, БХЭШХ-гийн захирал, профессор Б.Эрдэнэбат, НҮБ-ын Суурин зохицуулагч Тапан Мишра, ХБНГУ-ын Фридрих Эбертын сангийн суурин төлөөлөгч Бенедикт Ивановс, Гадаад харилцааны яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал Д.Гэрэлмээ нарын хүндэт зочид төлөөлөгчид оролцлоо. “Энхийг сахиулах ажиллагаанд Монгол эмэгтэйчүүдийн оролцоо” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын үндсэн итгэлийг ҮБХИС-ийн Сургалтын албаны дарга, хурандаа Г.Болор, БХЭШХ-гийн Эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D), дэд хурандаа Т.Мөнх-Оргил нар “НҮБ-аас Энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцооны талаар баримталж байгаа бодлого, гадаад улс орнуудын туршлага” сэдвээр

эхлүүлсэн бол үргэлжлүүлээд БХЯ-ын ГХАГ-ын ахлах мэргэжилтэн, хурандаа Ч.Нямсүрэн “Сьерра Леон улсад явагдсан UNMIL ажиллагаанд оролцсон эмэгтэйчүүдийн туршлага, сургамж”, Төрийн тусгай хамгаалалтын газрын Гадаад Харилцааны тасгийн дарга, ахлах дэслэгч Э.Ганчимэг “БНӨСУ-д явагдаж байгаа UNMISS ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн эмэгтэйчүүдийн туршлага, сургамж” зэрэг олон сонирхолтой хавсралт илтгэлүүдээр үргэлжиллээ. Сонирхуулахад, Монгол Улс НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд 2006 оноос хойш эмэгтэй алба хаагчийг илгээн үүрэг гүйцэтгүүлж байгаа билээ. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн “Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал” 1325 дугаар тогтоолын дагуу НҮБ-ын Энхийн ажиллагааны газраас “НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй эмэгтэй цэргийн

алба хаагчдын тоог 15 хувьд хүргэх тухай” албан даалгаврыг цэрэг илгээгч нийт улс орнуудад хүргүүлсэнтэй холбогдуулан Монгол Улс эмэгтэй цэргийн алба хаагчдынхаа оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч, өнөөгийн байдлаар илгээж байгаа эмэгтэй цэргийн алба хаагчдын тоогоор 112 улсаас 17 дугаарт, Зүүн хойд Азид 1 дүгээрт эрэмбэлэгдэж байна. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганд оролцохдоо НҮБ-аас энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэй алба хаагчдын оролцооны талаар бүс нутгийн болон олон улсын хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулахаа мэдэгдсэн нь Монгол Улс НҮБ-ын хэрэгжүүлж байгаа энхийг дэмжих бодлогод гишүүн орны хувьд ихээхэн ач холбогдол өгч байгаагийн илэрхийлэл юм.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 366,984 +873	ЭДГЭРСЭН 536,920	НАС БАРСАН 1,836 +10
----------------------------------	---------------------	-------------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 6382 +109	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 136	ЭДГЭРСЭН 6123
------------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 255,672,242

Эдгэрсэн

Нийт: 231,060,349

Нас барсан

Нийт: 5,137,834

спорт

МУГТ, ИХ МАСТЕР Б.МӨНГӨНТУУЛ ТЭРГҮҮН БАЙР ЭЗЭЛЛЭЭ



Энэ оны 10 дугаар сарын 27-ноос 11 дүгээр сарын 8-ны хооронд Латви Улсын Рига хотод зохион байгуулагдсан өндөр зэрэглэлийн "FIDE Chess.com Women's Grand Swiss" олон улсын тэмцээнд Үндэсний шигшээ баг, БХЯ-ны "Алдар" спорт хорооны дасгалжуулагч мэргэжилтэн, их мастер, ахмад Б.Мөнгөнтуул 11 өрөг тоглож 6.5 оноотойгоор 13 дугаар байрт шалгарсны зэрэгцээ олон улсын чансаагаа 10.4-өөр нэмсэн амжилт үзүүллээ.

Үргэлжлүүлээд 11 дүгээр сарын 9-ний өдөр алдарт шатарчин Михаил Талийн нэрэмжит олон улсын холимог нээлттэй түргэн тоглолтын тэмцээн амжилттай зохион байгуулагдсан юм. Уг тэмцээнд ахмад Б.Мөнгөнтуул 18 өрөг тоглож, 9 оноогоор эмэгтэйчүүдийн ангилалдаа тэргүүн байр эзлэн, 3000 доллароор шагнуулжээ.

"ИХ ДУУЛГА"-ААС "АЛДАР"-ЫН ТАМИРЧИД НЭГ МӨНГӨ, ХОЁР ХҮРЭЛ МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ



Өнгөрсөн сард Франц Улсын нийслэл Парис хотноо болсон "Парисын их дуулга-2021", энэ сарын 5-7-ны өдрүүдэд Азербайжан Улсын нийслэл Баку хотноо "Бакугийн их дуулга-2021" жүдо бөхийн тэмцээнүүдэд Монгол Улсын Жүдо бөхийн Үндэсний шигшээ багийн 23 тамирчин амжилттай оролцон эх орондоо ирээд байна.

Тус тэмцээнүүдээс Монгол Улсын жүдо бөхийн баг тамирчид нийт 6 медаль

хүртсэн амжилт үзүүлсэн юм. Тус 23 тамирчны 6 тамирчин нь БХЯ-ны "Алдар" спорт хорооны тамирчид бөгөөд эдгээрээс 3 тамирчин медаль хүртсэн юм. Тодруулбал, "Бакугийн их дуулга-2021" тэмцээний эмэгтэйчүүдийн -63, +78 кг-ийн жинд "Алдар" спорт хорооны тамирчин, дэд ахлагч Б.Ганхайч, тамирчин А.Адьяасүрэн нар мөнгөн медаль, "Парисын их дуулга-2021" тэмцээний эрэгтэйчүүдийн

60 кг-ийн жинд "Алдар" спорт хорооны тамирчин Э.Ариунболд хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.

Энэ удаагийн тэмцээнд таван тивийн 29 орны 195 жүдоч өрсөлдсөн бөгөөд Япон Улсын баг тамирчид 7 алт, 2 мөнгө, 2 хүрэл медаль хүртэж багийн дүнгээрээ тэргүүлсэн бол ОХУ-ын баг тамирчид 3 алт, 2 мөнгө, Израил Улсын баг тамирчид 2 алт, 1 хүрэл медальтайгаар удаалжээ.

30 КМ-ЫН МАРШ ҮЙЛДЭВ

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу байнгын бие бүрэлдэхүүнтэй тактик тусгай бэлтгэлийн цогцолбор 30 км-ийн явган маршийг хичээлийн 4 цэгээр төлөвлөн

зохион байгуулан явууллаа. Маршийн явцад отолтод орох үед өвчтөн, шархтанд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, хордсон газар орныг туулах, түр амралтын районд амьд гарах арга ухаан, цэргийн байр зүй, галын бэлтгэлийн хичээлийн

цэгүүдийг төхөөрөмжилж хичээл сургуулийг зохион байгуулж явуулав.

Мөн бие бүрэлдэхүүний дунд хээрийн халуун хоол, гранат шидэлтийн тэмцээнүүдийг зохион байгуулав. Хээрийн халуун хоолны тэмцээнд танкийн батальоны хоёрдугаар ротын хошигнол шарсан өвчүү, борцтой гурилтай шөл шалгарсан бол гранатын тэмцээнд үлээвэр найрал хөгжмийн салааны хамт олон тэргүүн байрыг эзэлж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ



"ЭХ ОРНЫ ТӨЛӨӨ ҮЗЭСГЭЛЭН" НЭЭГДЛЭЭ



Увс аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб Монгол улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн

байгуулагдсаны 100 жил тохиолдуулан Аймгийн цэргийн штаб, Хилийн цэргийн 0245 анги, Аймгийн музей

хамтран "Эх орны төлөө" үзэсгэлэн дэлгэлээ.

Эл үзэсгэлэнд эх орныхоо хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, ард иргэдийн аюулгүй байдлыг хамгаалахад оруулсан хувь нэмэр, гүйцэтгэсэн үүрэг, тусгаар тогтнолын төлөө алтан амиа зориулсан баатрууд, ахмад дайчдаараа бахархан омогшиж, үйл хэргийг нь мөнхжүүлэхийг тулд нийт ард иргэд, ялангуяа залуу үеийнхэн, хүүхэд, багачууддаа таниулахыг зорьж байгаа юм.

Хошууч Ж.ЦЭРЭНЧИМЭД

"ХАРАХ ӨНЦӨГ ХАНДЛАГААС ШАЛТГААЛНА" СЭДЭВТ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА



Зэвсэгт хүчний 310 дугаар анги Монгол Улсын Засгийн газраас баталсан "Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр", "Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Зэвсэгт хүчний алба хаагчдад чиглэсэн "Харах өнцөг хандлагаас шалтгаална" сэдэвт сургалтыг шат дараатай зохион байгуулсаар байна.

Энэ удаагийн

сургалтад Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн алба хаагчид хамрагдсан бөгөөд "Эерэг тэмүүлэл" ТББ-ын сургагч багш Э.Нямхүү, Хувь хүний хөгжлийн институтийн сургагч багш Э.Мөнх-Амгалан нар зочин багшаар оролцож олон сонирхолтой лекцийг хэлэлцүүлсэн юм. Тодруулбал, сургалтаар залуучуудын бие хүний онцлог, өгөгдмөл төрмөл авьяас чадварыг үнэлж сурах, генетикиношилгоог ганцаарчилсан уулзалтын

аргаар зохион байгуулав.

Мөн тус анги өнөөдөр 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу байнгын бие бүрэлдэхүүнтэй тактик тусгай бэлтгэлийн цогцолбор 30 км-ийн явган маршийг "Тактик тусгай бэлтгэл", "Цэргийн байр зүй", "Үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах", "Отолт зохион байгуулах", "Эмнэлгийн татан гаргалт" гэсэн хичээлийн 5 цэгээр төлөвлөн зохион байгууллаа.



* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффисеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ Батлан хамгаалах яам Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС "Соёмбо" сонин "Дуулга" студи